



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/100

Арвайхээр сум

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 15/06 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтын 13 дахь заалтад тусгагдсан Гучин-Ус сумын гэр хорооллын дулааны шугам сүлжээнд холбох зардалд 50,000,000 (тавин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0158

D:My Doc. Zahiramj. Zasag darga